

БАТЛАВ.  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА                   Д.СОЁЛЧХҮҮ

ОРХОН АЙМГИЙН ЗДТГазар

Огноо: 2019-05-10

## АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Төслийн нэр: Эрдэнэт хотын хөшөө, дурсгалын байгууламжуудад засвар хийх

Төслийн дугаар: ОР-49/2019

Орхон аймаг  
2019 он

## Нэг. ЦАХИМ ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Тендер шалгаруулалтын нэр: **Эрдэнэт хотын хөшөө, дурсгалын байгууламжуудад засвар хийх**

Тендер шалгаруулалтын дугаар: **ОР-49/2019**

Огноо:2019-05-10 өдөр

Орхон аймгийн ЗДТГ нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Эрдэнэт хотын хөшөө, дурсгалын байгууламжуудад засвар хийх” ажил гүйцэтгэх тухай ЦАХИМ үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулинд нийцүүлэн тендерийн баримт бичигт тодорхойлсон журам болон Харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгоно.

Энэхүү харьцуулалтын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа тул ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) хаягаар цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу.

Тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **30000 /Гучин мянган/** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна.

Үнийн санал нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна

Үнийн саналыг **2019 оны 05 сарын 20-ны өдрийн 10:00** цаг-аас өмнө [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) сайтаар орж өөрийн аж ахуй нэгжийн цахим гарын үсэг, хувийн нууцлалын кодоор нэвтэрч [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) сайтаар дамжуулан цахимаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2019 оны 05 сарын 20-ны 10:30** цагт **Орон нутгийн өмчийн газрын Сургалт мэдээллийн танхимд** нээнэ.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Орхон аймгийн Орон нутгийн өмчийн газар,  
Нутгийн удирдлагын ордон, 1 давхар 113 тоот өрөө,  
е-шуудан: [batnyagt@procurement.gov.mn](mailto:batnyagt@procurement.gov.mn)  
Утас:70358570

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |   |
|---|---|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч</b>      | <p>1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.</p>  |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b> | <p>2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө цаххимаар илгээнэ.</p> <p>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.</p>   |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>             | <p>3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ Унийн санал /маягтаар/ ирүүлэх.</li> <li>➤ Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь ирүүлэх.</li> <li>➤ Ажил гүйцэтгэх хуваарь ирүүлэх.</li> <li>➤ Улсын бүртгэлийн гэрчилгээ эх хувиас ирүүлэх.</li> <li>➤ Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, гэрээ, хавсралтыг эх хувиас ирүүлэх.</li> <li>➤ Тендерт оролцогчийг төлөөлж итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсэг зурах бол төлөөлөгч этгээдийн итгэмжлэл, итгэмжлэгчийн иргэний үнэмлэхийг эх хувиас ирүүлэх</li> <li>➤ Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татварын тодорхойлолт ирүүлэх шаардлагагүй бөгөөд Татварын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас тендерт оролцогчийн татварын өр, төлбөрийн талаарх мэдээллийг тендер нээсэн өдрийн байдлаар шалгах тул өр, төлбөргүй байх шаардлагатай.</li> <li>➤ Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтын цахим тодорхойлолтыг ТҮЦ машинаас авч эх хувиас ирүүлэх. /Тендер нээсэн өдрөөр өр төлбөргүй байна./</li> <li>➤ Шүүх байгууллагын тодорхойлт</li> <li>➤ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт</li> <li>➤ Харилцагч банкуудаас зээлтэй эсэх талаар тодорхойлолтыг ирүүлэх.</li> <li>➤ Гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг зөвшөөрч байгаа эсэх талаарх мэдэгдэлийг ирүүлэх.</li> <li>➤ Тендерт оролцогч нь (туслан гүйцэтгэгч бүрийг оролцуулан) уг ажлын зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээг хянах этгээдтэй нэгдмэл сонирхолтой эсэх талаар мэдэгдэлийг эх хувиар ирүүлнэ.</li> <li>➤ Татвар, Нийгмийн даатгал, шүүх, ШШГГ, харилцагч банк болон бусад байгууллагуудаас тендертэй холбоотой асуудлаар тодрууллага авахад татгалзах зүйлгүй тухай мэдэгдэлийг эх хувиас ирүүлэх.</li> <li>➤ Шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд баатаан ажлын зураг, техникийн тодорхайлолтын дагуу чанарын өндөр түвшинд тухайн ажлыг</li> </ul> |

- гүйцэтгэн дуусгаж ашиглалтанд хүлээлгэн өгөх тухай баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.
- Ижил төстэй ажлын гүйцэтгэл, чанар байдлын тодорхойлолтыг ашиглагч болон захиалагч байгууллагаас тус тус ирүүлэх. /2018 оны ажлын гүйцэтгэл хамаарах ба тодорхойлолтуудыг 2019 оны 3 сарын 1 өдрөөс хойш авсан байх шаардлагатай./
  - Санхүүгийн тайланг тендерт хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Сангиин яамны цахим санхүүгийн тайлангийн [www.e-balance.mof.gov.mn](http://www.e-balance.mof.gov.mn)-ээс тендерт оролцогчдын татвар төлөлт, санхүүгийн тайлангаас борлуулалтын орлого, шаардлагатай мэдээллүүдийг шалгана.
  - Тендерт оролцогч нь ажлыг богино хугацаанд чанартай гүйцэтгэх ИТАжилтан, мэргэжлийн ажилтан, ажилчдын нотлох баримтыг ирүүлнэ. Үүнд:
    - Инженер, техникийн ажилтнууд, мэргэжлийн ажилтан, ажилчдын чадавхийн мэдээлэлийг ТШМ 2-7, ТШМ 2-8 маягтуудаар ирүүлэх ба диплом, мэргэжлийн үнэмлэхийг эх хувиас ирүүлэх.
    - ИТА –үүд нь үндсэн ажилтнууд байх ба сүулийн 3 сарын НД-8 маягтыг эх хувиас ирүүлэх.
    - Техник тооног төхөөрөмжийн чадавхийн мэдээлэлийг МАЯГТ № ТШМ 2-6 маягтаар гаргаж ирүүлэх.
    - Ажлын тоо хэмжээ бүрэн тооцсон төсөөв ирүүлэх (эрх бүхий төсөөвчнөөр хийлгэж баталгаажуулсан байх)
    - Тухайн ажилд ашиглагдах бараа материалын сертификат, гарал ууслийн гэрчилгээг ирүүлэх.
    - Тендерийн бичиг баримтны гадаад хэл дээрх материалуудыг баталгаат орчуулга хийж ирүүлэнэ.
    - Төсөөвт ажлын тоо хэмжээг бүрэн авч тооцох, бусад холбогдох зардуудыг норм нормативын дагуу бүрэн гүйцэд тооцох, зураг төслийн зардалд 249 999 төгрөгийг төсөөвт суулгаж тооцоно.
    - Тухайн барилгын ажилд ашиглагдах барилгын бараа материалуудаас ЗГ-ын 2015 оны 336-р тогтоолын хавсралтанд заасан барилгын материалуудыг дотоодын үйлдвэрлэгчээс авч ашиглах, түүнийгээ нотлосон бичиг баримтыг ирүүлэх.

**Дээрхи бичиг баримтуудыг PDF хэлбэрт шилжүүлэн цахим хэлбэрээр ирүүлнэ. Харилцагч байгууллага, захиалагч ашиглагч нарын тодорхойлолт, албан бичиг, бичиг баримтуудыг эх хувиас ирүүлэх ба огноо нь тендер зарласан хугацаанд байна. мэдээллүүдийг бүрэн ирүүлээгүй буюу худал мэдээлэл ирүүлсэн нөхцөлд тендерээс татгалзах үндэслэл болно.**

- |                         |  |
|-------------------------|--|
| <b>4. Тендерийн үнэ</b> | 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцгчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.<br><br>4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно. Үнийн хөнгөлөлтийг ямар зардлаас яаж тооцсон тухай албан бичгийг заавал ирүүлэнэ. |
|-------------------------|--|

- 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
- 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
  - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
  - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үргүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцгчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

## Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-НЫХОЛБОГОХЗААЛТ	Шалгуур үзүүлэлт																							
ТОӨЗ 1.1	<p>1. 2018 онд төсөөт өртөгийн үнийн дүнгээс багагүй хэмжээний ижил төстэй ажлуудыг хийж гүйцэтгэсэн туршлагатай байх Мэдээлэлийг маягтаар ирүүлэх. Гүйцэтгэсэн ажлын гэрээ, хүлээлгэн өгсөн актыг эх хувиас ирүүлэх. /Ижил төстэй ажилд барилгын засварын ажлыг ойлгоно./</p> <p>2. 2018 оны борлуулалтын орлого батлагдсан төсөөт өртөгийн үнийн дүнгээс багагүй байх</p> <p>3. Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: БХЯамны</p> <ul style="list-style-type: none"> <li>• 2.1.1. Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт Шинэ журмаар бол</li> <li>• БА-8.1 Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьерьер, орчны тохижилтын ажил</li> </ul> <p>4. Дараах үндсэн тоног төхөөрөмжийг ажлыг гүйцэтгэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах шаардлагатай. Үүнд:</p> <table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <thead> <tr> <th>№</th> <th>Тоног төхөөрөмжийн нэр</th> <th>Хүчин чадал</th> <th>Тоо ширхэг</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Автомашин</td> <td>Бага оврын</td> <td>1</td> </tr> </tbody> </table> <p>Эдгээр техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлийг бэлэн байгааг нотлох баримтыг фото зургийн хамт ирүүлнэ. Анхаарах: Гэрээт ажилд ашиглах машин механизм, тоног төхөөрөмжийн гэрчилгээг эх хувиас ирүүлэх, Түрээсээр ашиглах бол түрээсийн гэрээ, гэрчилгээг наториатаар баталгаажуулан ирүүлэнэ.</p> <p>5. Тендерт оролцогч нь ажлыг богино хугацаанд чанартай гүйцэтгэх дараах үндсэн ИТА-тай байна. Үүнд:</p> <table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <thead> <tr> <th>№</th> <th>Албан тушаал</th> <th>Ажиллах хүчиний тоо</th> <th>Туршлага, ажилласан жил</th> <th>Мэргэжил</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Барилгын техникч</td> <td>1</td> <td>5</td> <td>Барилгын инженер</td> </tr> <tr> <td>2</td> <td>ХАБЭА-н ажилтан</td> <td>1</td> <td>1</td> <td>Сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан байх</td> </tr> </tbody> </table> <p>Төсөлд ИТА-нуудыг хөдөлмөрийн гэрээгээр түр ажилуулж болох ба нотлох баримтыг ирүүлнэ. Дээрхи бичиг баримтуудыг PDF хэлбэрт шилжүүлэн цахим хэлбэрээр ирүүлнэ.</p>	№	Тоног төхөөрөмжийн нэр	Хүчин чадал	Тоо ширхэг	1	Автомашин	Бага оврын	1	№	Албан тушаал	Ажиллах хүчиний тоо	Туршлага, ажилласан жил	Мэргэжил	1	Барилгын техникч	1	5	Барилгын инженер	2	ХАБЭА-н ажилтан	1	1	Сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан байх
№	Тоног төхөөрөмжийн нэр	Хүчин чадал	Тоо ширхэг																					
1	Автомашин	Бага оврын	1																					
№	Албан тушаал	Ажиллах хүчиний тоо	Туршлага, ажилласан жил	Мэргэжил																				
1	Барилгын техникч	1	5	Барилгын инженер																				
2	ХАБЭА-н ажилтан	1	1	Сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан байх																				
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: <b>Тендер хүлээж авах эцсийн хугацаа нь Цахим худалдан авах ажиллагааны систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>)-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй.</b> Огноо: [2019 оны 05 сарын 20-ны өдөр] Цаг: 10 цаг 00 минут</p>																							
ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: <b>Байгууллагын хаяг: [Орхон аймгийн ЗДТГ, Нэг цонхны үйлчилгээ, Сургалт мэдээлэлийн танхим ]</b> Огноо: [ 2019 оны 05 сарын 20-ны өдөр] Цаг: [10 цаг 30 минут]</p>																							
ТОӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>Багцгүй</b>																							

БАТЛАВ.  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА                   Д.СОЁЛЧХҮҮ

## Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Гүйцэтгэгч үе шатны ажлын үед зохиогч болон захиалагчийг дуудаж далд ажлын акт үйлдэж баталгаажуулна.
2. Ажлын тоо хэмжээг сонгон шалгаруулалтанд оролцогчийн удирдамж, гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, техникийн тодорхойлолт болон зурагтай холбож ойлгоно.
3. Ажлын тоо хэмжээнд тодорхойлсон магадлашгүй ажлын зардлыг зарцуулахад захиалагчийн зөвшөөрөл баталгааг авна.
4. Үнэлсэн ажлын тоо хэмжээнд тусгагдсан үнэ өртөгийн ажлыг тоог заасан заагаагүй, аль ч нөхцөлд тодорхойлсон байна. Гүйцэтгэгчийн бөглөөгүй орхисон үнэ өртөгийг ажлын хэмжээнд тусгасан бусад ажлуудад шингээсэн гэж ойлгоно.
5. Гэрээний нөхцлийн дагуу шаардагдах бүх зардлыг ажлын тоо хэмжээнд тусгасан ажлуудад шингээсэн гэж үзэн ямар нэгэн ажил тодорхойлоогүй үлдээсэн тохиолдолд түүний үнэ өртөг нь холбогдох ажлын үнэ өртөгт шингээсэн гэж үзнэ.
6. Хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааг хуульд заасны дагуу мөрдөж, түүнд шаардагдах хөрөнгийг хуулийн дагуу төлөвлөж, ажлын төсөвт багтааж, зарцуулах
7. Оршин суугчдын аюулгүй байдлыг бүрэн хангаж, ажлын байр, зам гарц, талбайг хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэмд заасны дагуу бэлтгэж, үйлдвэрлэлийг аюулгүй гүйцэтгэх нөхцлийг бүрэн хангах, хааша хамгаалалтыг хийж оршин суугчдын зорчих хэсгийг гаргаж анхааруулах тэмдэг, тэмдэглэгээг хийх. Ажилтнууд хамгаалах хэрэгслэлээр бүрэн хангагдсан байна.
8. Гүйцэтгэгч нь ашиглагч, хангагч байгууллагуудтай уялдаатай ажиллах бөгөөд тендерийн баримт бичигт заасан хугацаан дотор ажил гүйцэтгэх хуваарийг боловсруулж тендерийн баримт бичигт ирүүлнэ.
9. Ажлыг гүйцэтгэх үед тухайн орчны тохижилт, холбоо, цахилгаан, интернетийн кабель утсыг гэмтээсэн тохиолдолд гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр түргэн шуурхай засварлан хангагч байгууллагад хүлээлгэн өгнө.
10. Гүйцэтгэгч нь хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагааны нөхцөлийг бүрэн хангах, үүнээс гарах хор хохирлыг өөрсдөө хариуцна. Байгалийн гэнэтийн гамшиг, гол түймэр, үер усны гамшигаас сэргийлэн аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллана.
11. Тухайн гүйцэтгэсэн ажилдаа Барилгын тухай хуулийн 14.3, 14.6 дахь заалтуудын дагуу тохируулга, ашиглалтын хугацааны баталгааг бичгээр гаргаж тендерийн баримт бичигт ирүүлнэ.
12. Тендерт шалгарсан оролцогч нь ажлын талбайд гэрээ байгуулсаны дараа З хоногийн дотор Компаний товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж байгаа ажлын нэр, гэрээний үнийн дүн, ажил эхлэх болон дуусах хугацаа зэргийг багтаасан мэдээллийн самбарыг төв, суурин бүрийн олон нийтэд үзэгдэхүйц газар байрлуулсан байна.

**Тав. ЗУРАГ**

Батлагдсан зургийн дагуу ажлыг гүйцэтгэх.

**Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ**

Ажил гүйцэтгэх график, болон үнэлэгдсэн үе шатны ажлын график ирүүлэх

**Долоо. ЖИШИГ МАЯГТ**

**ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

**Хавсралт. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО  
ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ**

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаarahгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

**ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТЕХНИКИЙН ХҮЧ ЧАДАЛ**  
**(ТӨСЛИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХЭД АШИГЛАХ МАШИН МЕХАНИЗМ**  
**ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, АЖЛЫН БАГАЖ ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ)**

Д/д	Машин механизм, тоног төхөөрөмж, ажлын багаж хэрэгслийн нэр, марк	Тодорхойлолт, хаана үйлдвэрлэсэн, ашиглагдсан хугацаа /жилээр/	Хүчин чадал, тоо ширхэг	Ашиглалтын байдал (шинэ, сайн, хуучин), хэдэн оноос ашиглаж байгаа	Өөрийн, түрээслэх, эсхүл худалдаж авах
A.	Үндсэн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл				
B.	Хяналт, шалгалтын багаж хэрэгсэл				

Тайлбар: Зөвхөн тухайн төслийг хэрэгжүүлэх ажлын талбай дээр байнга ажиллах тоног төхөөрөмж, машин механизм, ажлын багаж хэрэгслүүдийн тодорхойлолтыг бичнэ.

Тэмдэг

ГАРЫН ҮСЭГ \_\_\_\_\_

ОВОГ НЭР \_\_\_\_\_

КОМПАНИЙН НЭР \_\_\_\_\_

**ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛТАН, АЖИЛЧДЫН ЧАДВАР,  
ТУРШЛАГЫН ТОДОРХОЙЛОЛТ**

Д/д	Албан тушаал	нэр	Ажилласан жил (нийт)	Санал болгож буй албан тушаалтай ижил албан тушаалд ажилласан жил

Тайлбар: Гэрээнд санал болгож буй удирдах, хяналт тавих, тодорхой ажил, үйлчилгээг гүйцэтгэх ажилтан, ажилчдын боловсрол, мэргэжлийн ур чадвар, туршлагын талаарх мэдээллийг хавсаргана.

ГАРЫН ҮСЭГ \_\_\_\_\_

ОВОГ НЭР \_\_\_\_\_

КОМПАНИЙН НЭР \_\_\_\_\_

МАЯГТ № ТШМ 2-8

### АЖИЛЛАХ ХҮЧ

(Төслийн ажлыг гүйцэтгэх гол мэргэжилтнүүдийн тодорхойлолт)

1. Овог нэр:

2. Нас:

3. Боловсрол:

4. Мэргэжил:

5. Мэргэжлээрээ ажилласан жил:

6. Төсөлд гүйцэтгэх үүрэг:

7. Төсөлтэй холбоотой ажлын туршлага:

Тайлбар: Энэ тодорхойлолтод төслийн удирдах, хяналт тавих, тодорхой ажил, үйлчилгээг гүйцэтгэх ажилтан, ажилчид хамрагдана.

Тэмдэг                    ГАРЫН ҮСЭГ \_\_\_\_\_  
                              ОВОГ НЭР \_\_\_\_\_  
                              КОМПАНИЙН НЭР \_\_\_\_\_

## Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |  |
|---|--|
| <b>1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх</b>                         | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.   |
| <b>2. Төслийн менежерийн шийдвэр</b>                        | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.  |
| <b>3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх</b> | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.   |
| <b>4. Аюулгүй байдал</b>                                    | <p>4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.</p> <p>4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.</p> |
| <b>5. Зааварчилгаа</b>                                      | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй   |
| <b>6. Маргааныг шийдвэрлэх</b>                              | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.  |

## Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ

- |                                     |   |
|-------------------------------------|---|
| <b>7. Ажлын хөтөлбөр</b>            | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.  |
|                                     | 7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.   |
| <b>8. Зөрчил, гологдол илрүүлэх</b> | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдолын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй. |

- |   |  |
|---|--|
| <b>9. Зөрчил, гологдол арилгах</b>          | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа <sup>1</sup> дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.<br><br>9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана. |
| <b>10. Зөрчил, гологдол арилгахгүй байх</b> | 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.  |

## В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- |   |   |
|---|---|
| <b>11. Үе шатны ажлын хуваарь</b>           | 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 7 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарын тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.<br><br>11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ. |
| <b>12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх</b> | 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарын нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.   |
| <b>13. Алданги</b>                          | 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги <sup>2</sup> төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс сүтгэн авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.                                 |

## Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- |                          |   |
|--------------------------|---|
| <b>14. Ажил дуусгах</b>  | 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлцуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна. |
| <b>15. Хүлээж авах</b>   | 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.  |
| <b>16. Эцсийн тооцоо</b> | 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ.<br><br>Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол                          |

<sup>1</sup> Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

<sup>2</sup> Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.

Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

- |  |   |
|--|---|
| <b>17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага</b> | <p>17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.</p> <p>17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлэгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстай төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.</p>   |
| <b>18. Гэрээг цуцлах</b>                               | <p>18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.</p> <p>18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:</p> <ul style="list-style-type: none"> <li>(а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;</li> <li>(б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;</li> <li>(в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;</li> <li>(г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;</li> <li>(д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.</li> </ul> <p>18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.</p> |
| <b>19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр</b>             | <p>19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.</p>  |

- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.
- 20. Гүйцэтгэлээ с чөлөөлөх**
- 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсоно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ<sup>3</sup>

<b>ГЕН 2.1</b>	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: <b>Эрдэнэт хотын хөшөө, дурсгалын байгууламжуудад засвар хийх, ОР-49/2019</b>
<b>ГЕН 2.1</b>	Барилгын дээврийн засварын ажлуудаас бүрдэнэ.
<b>ГЕН 3.1</b>	Төслийн менежер нь <b>Гэрээний хэлэлцээр хийх үед тодорхойлно.</b>
<b>ГЕН 4.1</b>	<p>Ажил эхлэх өдөр <b>Гэрээ батлагдсан өдрөөс эхлэн ажил эхлэх өдөр тооцогдоно.</b></p> <p>Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр: <b>Үг ажлыг хуанлийн 21 хоногт хийж гүйцэтгэнэ.</b></p>
<b>ГЕН 7.1</b>	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш <b>[ажлын 5]</b> хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
<b>ГЕН 9.1</b>	Чанарын баталгаат хугацаа: <b>МУ-ын барилгын тухай хуулийн 14.3 Барилга байгууламжийг ашиглалтанд зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна. 14.6 Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтэц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж тоноглолтын хэсийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна.</b>
<b>ГЕН 13.1</b>	<p>Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн <b>[0.05 хувь]</b> байна.</p> <p>Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн <b>[10 хувь]</b> байна.</p>
<b>ГЕН 17.1</b>	<p>Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлага бусад холбогдох бичиг баримтуудыг <b>[ашиглалтанд хүлээлгэн өгөх хугацаанаас өмнө]-ны</b> дотор гаргаж өгнө.</p> <p>Гүйцэтгэлийн зургийг <b>[Ажлын үе шат бүрт баталгаажуулж ажиллана]-ны</b> дотор гаргаж өгнө.</p> <p>Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд сутгах төлбөрийн хэмжээ <b>[үнийн дүнгийн 0,01 хувиар хоног тутам суутгал хийнэ]</b> байна.</p>
<b>ГЕН 19.1</b>	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын <b>[100 хувь]-иар тооцно.</b>

<sup>3</sup> Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

Арав. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ сарын \_\_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулхтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: \_\_\_\_\_ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь \_\_\_\_\_ байршилтай \_\_\_\_\_  
хүчин чадал бүхий \_\_\_\_\_ ам.метр талбай / \_\_\_\_\_ шоо метр эзлэхүүн/-тай,  
\_\_\_\_\_ суурь, \_\_\_\_\_ хана,  
\_\_\_\_\_ хучилттай, \_\_\_\_\_ давхар \_\_\_\_\_ барилга  
угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг \_\_\_\_\_  
инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/,  
\_\_\_\_\_ туслах барилга /бусад ажил/-ын хамт \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар  
сарын \_\_\_\_\_-ны өдөр эхэлж, \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана

#### **ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Гарын

үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансн.  
дугаар]

#### **ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Гарын

үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансн.  
дугаар]